

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн нэгдүгээр бүлгийн зургаадугаар зүйлд заасны дагуу 2019 онд МҮОНРТ-ээс хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хураангуй тайланг олон нийтэд толилуулж байна.

“Олон нийтийн радио, телевизийн тухай” Монгол Улсын хуулийн 25.2-д Үндэсний зөвлөлийн хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хийхээр заасан байдаг. МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл нь 2019 оны тайлант хугацаанд нийт есөн удаа хуралдаж, нийт 33 тогтоол шийдвэрийг гаргаж ажилласан байна.

Үндэсний зөвлөлийн Хяналтын зөвлөлөөс тухайн онд есөн санал дүгнэлтийг бэлтгэж Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж танилцуулсан байна. Мөн Хяналтын зөвлөлийн дэргэдэх дотоод аудит нь 2019 оны батлагдсан төлөвлөгөөгөөр нийтдээ хоёр тайлан бэлтгэж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэн гүйцэтгэх удирдлагад зөвлөж дүгнэлтээ хүргүүлээд байна.

НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД

Тухайн онд Үндэсний зөвлөлийн гишүүн Д.Гоошоохүү, Л.Пүрэвдорж, А.Арман, С.Мягмар нарын бүрэн эрхийн хугацаа дууссан Үндэсний зөвлөлийн гишүүн С.Санасэрийг Үндэсний зөвлөлийн хуралдаанд зургаан сараас дээш хугацаагаар биечлэн оролцоогүй гэх шалтгаанаар 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн Улсын Их Хурлын дугаар 31 тоот тогтоолоор чөлөөлжээ. Мөн 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн Улсын Их Хурлын дугаар 30 тоот тогтоолоор Үндэсний зөвлөлийн гишүүн Н.Жанцан, Д.Өлзийбаатар, В.Баг-Эрдэнэ, Д.Батсүх, С.Алтанцэнэг нарыг томилсон байна.

Мөн Хяналтын зөвлөлийн гишүүн Г.Энхбаярын хугацаа дуусгавар болж 2019 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн Үндэсний зөвлөлийн дугаар 05 тоот тогтоолоор чөлөөж, Үндэсний зөвлөлөөс ажлын хэсэг байгуулж Хяналтын зөвлөлийн гишүүний нэг орон тоон дээр сонгон шалгаруулалт явуулж, олонхын санал авсан Б.Баясгаланг Үндэсний зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн дугаар 15 тоот тогтоолоор томилсон байна.

ХОЁР. ОНРТ-ийн тухай хуулийн 25.9 заалтын дагуу Үндэсний зөвлөлийн хуралдаан болон үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэгдсэн байдал

| Д/д | Хуралдааны огноо | Мэдээлэгдсэн байдал |
|-----|------------------|--|
| 1 | 2019.01.29 | МҮОНРТ-ийн 2-р суваг “Монголын мэдээ” телевизийн 18:00 цагийн мэдээллийн хөтөлбөр урсдаг мэдээгээр |
| 2 | 2019.04.11 | МҮОНРТ-ийн 2-р суваг “Монголын мэдээ” телевизийн 18:00 цагийн мэдээллийн хөтөлбөр урсдаг мэдээгээр “ |
| 3 | 2019.04.30 | МҮОНРТ-ийн www.mnb.mn Цахим хуудсаар |
| 4 | 2019.05.09 | МҮОНРТ-ийн www.mnb.mn Цахим хуудсаар |
| 5 | 2019.08.06 | МҮОНРТ-ийн 1, 2-р суваг “Монголын мэдээ” телевизийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрөөр |
| 6 | 2019.12.27 | МҮОНРТ-ийн 1, 2-р суваг “Монголын мэдээ” телевизийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрөөр |

ГУРАВ. ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛӨӨС ГАРГАСАН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Үндэсний зөвлөлийн тогтоолууд хэрэгжсэн байдлаас харахад гадаад томилолттой холбоотой тогтоолууд ихэнх нь хэрэгжээгүй. Гадаад томилолттой холбоотой нийт зургаан тогтоол гарсаны зөвхөн хоёр нь тухайн ондоо хэрэгжсэн байна.

Мөн “ОНРТ-ийн тухай” хуулийн 25.9 заалтын дагуу МҮОНРТ-ийн 2018 оны хөндлөнгийн аудитаас Үндэсний зөвлөлд “Байгууллагын төсвийг багтахдаа үндэслэлтэй, тооцоололтой, судалгаатай, орлого зардлын ангилал зүйл бүрээр нарийвчлан баталж байх тухай” зөвлөмж хүргүүлсний дагуу 2020 оны төсвийг орлого, зарлагын нарийвчилсан задаргаатай баталсан байна. /Тогтоол №32/

ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

“ОНРТ-ийн тухай” хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх чиглэлд зарим шинэлэг ажлыг хийж хэрэгжүүлсэн. МҮОНРТ-ийн хуулиар хүлээсэн нэг үүрэг бол “улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнолыг сахин хамгаалахад олон нийтийг мэдээллээр хангах онцгой үүрэгтэй байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол радио телевиз” гэж заасан байдаг.

Тиймээс хамтын ажиллагааны хүрээнд 2019 онд хийгдсэн ажлуудын нэг бол Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлтэй хамтын ажиллагааг шинэ шатанд гаргасан явдал байв. Хамтын ажиллагааны хүрээнд МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл, Захирлуудын зөвлөл болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албатай хамтарсан “Үндэсний аюулгүй байдлын номлол, үзэл баримтлал”, “Дотоод аюулгүй байдал”, “Орчны аюулгүй байдал” “Хүнсний аюулгүй байдал” гэсэн дөрвөн дэд хэсгийг байгуулан ажиллаж байна. Ингэснээр “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх чиглэлээр Үндэсний зөвлөлөөс тусгайлан чиглэл өгч, үзэл баримтлалын гол, гол заалтыг хүүхэд, залуучуудаас эхлэн иргэн бүрт хүргэж сурталчлах ажлыг шинэ шатанд гаргасан.

ТАВ. ХӨДӨӨ ОРОН НУТАГТ АЖИЛЛАСАН БАЙДАЛ

МҮОНРТ-ийн хөдөө орон нутаг дахь 1960-1994 онд ашиглалтад орсон орон нутгийн хураамжийн тасгийн байрнуудын нөхцөл, байдлыг газар дээр нь очиж үзэж, танилцах ажлын хэсгүүдийг байгуулан Үндэсний зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу Үндэсний зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүд газар дээр нь очиж ажилласан.

Дээрх шалгалтын дараа Үндэсний зөвлөлөөс МҮОНРТ-ийг орон нутагт төлөөлж буй хураамжийн тасгийг орчин үеийн оффисын өрөө тасалгаагаар өөрчлөн, ажилчдын ажиллах нөхцөл, техник хэрэгслийг сайжруулах, шаардлага хангахгүй болсон үл хөдлөх хөрөнгийг зохих хууль, дүрэм, журмын дагуу зах зээлийн үнээр худалдан борлуулах, цаашид оффисын өрөө тасалгааг нийтийн орон сууцанд бус үйлчилгээний төв, эрчим, шуудан холбоо гэх мэт газруудын дэргэд авах, түрээслэхэд анхаарах, орон нутагт ажиллаж буй телевиз, радиогийн сурвалжлагч, хураамжийн тасгийн ажилчдыг нэг дор төвлөрүүлэн ажиллуулах нөхцөл, боломжийг судлах зэрэг үүрэг даалгаврыг гүйцэтгэх удирдлагад өгсөн.

ЗУРГАА. ДОТООД ХЯНАЛТЫН ХҮРЭЭНД

Хяналтын зөвлөлийн дэргэдэх дотоод аудит нь 2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу хоёр удаа тайлан бэлтгэж, Үндэсний зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэн гүйцэтгэх удирдлагад зөвлөмж, дүгнэлтээ хүргүүлж ажилласан байна. Дотоод хяналтын ажлын хүрээнд тус онд дотоод аудитын зүгээс МҮОНРТ-ийн 2018 оны санхүү, төсвийн үйл ажиллагаа, төсөв зарцуулалтын үр дүн, 2019 оны эхний хагас жилийн төсөв зарцуулалтад тус тус түүвэрчилсэн шалгалтыг хийж гүйцэтгэн ҮЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, тайланг гүйцэтгэх удирдлагад хүргүүлэв. Уг шалгалтаар нийт 17 асуудал илрүүлэн асуудлын хүрээнд холбогдох зөвлөмжүүдийг гаргасан бөгөөд ҮЗ-ийн тогтоолоор гүйцэтгэх удирдлагад зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах үүрэг өгч ажилласан байна.

ДОЛОО. УРАН БҮТЭЭЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭНД

МҮОНРТ-ийн 85 жилийн ойг 2019 онд тэмдэглэн өнгөрүүлж, радиогийн хамт олны хувьд нэвтрүүлгийн агуулга, хамрах хүрээг өргөжүүлэх, технологийн шинэчлэлийг үргэлжлүүлэх олон ажлыг амжилттай хэрэгжүүлэв.

МҮОНРТ-ийн бүх суваг, уран бүтээлчид, тэнд ажиллаж байгаа хамт олон хуулийн дагуу хүлээсэн үүргээ амжилттай сайн хэрэгжүүлсэн гэдгийг онцолж байна. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн “Ninja warrior” шоу нэвтрүүлгийг “Монгол нинжа дайчид” нэртэйгээр шинэчилж, бэлтгэн, монголын хөрөнд нутагшуулж, анхны нэвтрүүлгийг зохион байгуулсан. Үүнийг МҮОНРТ-ийн шинэ тутам байгуулагдсан “MNB спорт” сувгийнхан бүтээж, эх орондоо болон гадаадад болж буй спортын уралдаан, тэмцээнүүдийг шууд дамжуулан олон нийтэд хүргэх их ажлын хажуугаар түгээж чадсан нь энэ оны телевизийн нэвтрүүлгийн бодлогод томоохон байр суурь эзэлнэ.

Шинэ тутам суваг болох англи хэл дээр нэвтрүүлэг явуулдаг “MNB World” суваг улам бүр олон нийтэд танигдсаар байна. 2019 оны хувьд энэ сувгийг бид туршилтын журмаар ажиллуулсан. Одоогоор гадаад орнууд руу цацах ажлыг ганцхан цахим хэлбэрээр хийж байгаа ч сэтгүүлчид, ажилтнуудын маань хувьд уг сувгийн мэдээ, нэвтрүүлгүүдийг тасралтгүй явуулахад нэлээд туршлагажиж, суваг маань тогтвортой ажиллах бололцоотой болсоор байна.

МҮОНРТ-ийн нэгдүгээр суваг соёл, зан заншил, уламжлал, боловсрол, соёл, урлаг болон хүүхэд, залуучуудад зориулсан өргөн хүрээтэй нэвтрүүлэг явуулдаг. Хүүхдийн тухай нэвтрүүлэг, түүн дотроо гэр бүлийн харилцааны асуудал, эцэг, эхийн хүүхдээ хүмүүжүүлэх үүрэг, залуу үеийн тухай, Монгол гэр бүлийг бүхэлд нь хамарсан бодлогын нэвтрүүлгүүдийг цаашидаа бие даасан сувгаар гаргах бодит шаардлага тулгарч байна. МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн зүгээс “ОНРТ-ийн тухай” хуулиар хүлээсэн үүргийг дахин төрөлжүүлэх үүднээс МҮОНРТ-ийн тав дахь суваг буюу “MNB Гэр бүл” сувгийг нэх бодлого баримталж, 2019 оноос зарим туршилтын ажлуудыг эхлүүлээд байна.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ




УДИРДЛАГА, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


МҮОНРТ-ийн 2019 оны төсвийн төсөл, үйл ажиллагааны төлөвлөгөөг өнгөрсөн жилийн гүйцэтгэл, тус онд хэрэгжүүлэх тэргүүлэх чиглэл, салбар нэгжийн санал зэрэгт үндэслэн боловсруулж Үндэсний зөвлөлд хүргүүлэн хэлэлцүүлж, төсвийн болон үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулав. /2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 49 дүгээр тогтоол/

МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлөөс 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 46 тоот тогтоолоор орон тооны дээд хязгаарыг 802 орон тоогоор шинэчлэн баталсан ба тогтоолыг баримтлан Захирлуудын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хурлаар “МҮОНРТ-ийн зохион байгуулалтын нэгжүүдийн бүтэц орон тоо, ажил албан тушаалын жагсаалт”-ыг хэлэлцэж шинэчлэн баталсны мөрдөн ажиллав.

МҮОНРТ-ийн үндсэн үйлдвэрлэл болон дэмжих салбарын ажилтнуудын харьцаа



Үндсэн үйлдвэрлэлийн салбар



Дэмжих салбар



МҮОНРТ нь бүтэцдээ анх удаа бие даасан Эрэн сурвалжлах редакциятай боллоо. Эрэн сурвалжлах редакц нь “Анхаарах өнцөг”, Баримт” эрэн сурвалжлах нэвтрүүлгүүдийг долоо хоног бүр бэлтгэн эфирт нийлүүлж байна. Тус редакцын сэтгүүлчид “Талийгсдаа хайсан монголчууд” гурван цуврал, “Эрээний импорт шингэсэн эрдмийн дүрэмт хувцас” цуврал нэвтрүүлэг бэлтгэж, харин “Анхаарах өнцөг” нэвтрүүлгээр хүүхдийн хүчирхийлэл, Эрүүгийн хуулийг амьдралд ашиглаж байгаа жишиг, цахим халдлагын золиос, үл хөдлөх хөрөнгийн луйвар, малын түүхий эдийн үр ашиггүй хаягдал гэх мэт сэдвүүдийг хөндлөө.

МҮОНРТ-ийн Захирлуудын зөвлөл нь 2019 оны төлөвлөгөө, төсөл, байгууллагын дотоод бүтэц, зохион байгуулалтыг батлах, байгууллагад мөрдөгдөж буй зарим журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр батлах, сонгон шалгаруулалтаар худалдан авалт хийх зөвшөөрөл олгох, салбар нэгжүүдийн дотоод бүтэц зохион байгуулалтын асуудал, Үндэсний Зөвлөлөөс холбогдох зөвшөөрлүүдийг авах тухай зэрэг байгууллагын өмнө тулгамдсан бүх төрлийн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

Тайлант хугацаанд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэсэн Ерөнхий захирлын нийт 889 /үүнээс А-139, Б-750/ тушаал батлагдан гарч хэрэгжсэн байна.

МҮОНРТ нь хууль, журам, дүрмийн дагуу 2019 онд иргэн, хуулийн этгээдтэй 580 гэрээ байгуулан ажиллажээ.

Олон нийтийн өмчийг эзэнтэй болгох, үнэгүйдэхээс сэргийлж МҮОНРТ-ийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хөндлөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагаар хийлгэв. МҮОНРТ-ийн нийт хөрөнгийг 20.5 тэрбум төгрөгөөр үнэлэв.

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт хамрагдаж, “Сайн” дүнтэй үнэлэгдэв.

Чадварлаг хүний нөөц бүрдүүлж, чанартай контент бүтээх зорилт тавин МҮОНРТ-ийн сэтгүүлч, уран бүтээлч, инженер техникийн ажилтнуудын ажиллах орчин нөхцөл, цалин, тэтгэмж, урамшуулалд анхаарч ажиллав. Хэдийгээр эдийн засгийн хүндрэлээс зарим зардлыг бууруулсан ч ажилтнуудынхаа цалинг нэмэгдүүлэх тооцоо, судалгаа хийж 2019 оны 06 дугаар сарын 01-нээс үндсэн цалинг 50,000 төгрөгөөр нэмэгдүүлснээр нийт ажиллагсдын дундаж цалин хөлс 944,000 төгрөг боллоо. МҮОНРТ-ийн ажилтнуудын 2019 онд ажилласан хугацааг харгалзан тус бүр 190,000-380,000 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгов.

Түүнчлэн 2019 оноос эхлэн захиргаа, үйлчилгээний ажилтнуудад ажлын онцлог шинж чанар, ажлын тайлан, үр дүн, ажил гүйцэтгэлийн түвшин, ажил гүйцэтгэх үр чадвар зэргийг харгалзан үр чадварын нэмэгдэл олгож эхэллээ.

Ажилтнуудынхаа эрүүл мэнд, нийгмийн хамгаалалд анхаарч Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран давхардсан тоогоор 1016 ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулснаас гадна “MNB фитнес” төвийг засварлан тохижуулж өдөр тутам ажилтнууддаа үйлчилж хэвшив. МҮОНРТ-ийн ажиллагсад болон Чингэлтэй, Баянгол дүүргийн хамрах хүрээний хороодын 2-5 насны хүүхдүүдийн сурч хүмүүжих, сургуулийн өмнөх боловсрол олгох зорилготой “MNB-ийн хүүхдүүд” цэцэрлэг гурав дахь жилдээ элсэлт авч, 105 хүүхдийг төгсгөлөө. Тус цэцэрлэгийн үйл ажиллагааг БСШУСЯ болон МХАҮТ-аас сайшаасан юм.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн нэгдүгээр бүлгийн зургаадугаар зүйлд заасны дагуу 2019 онд МҮОНРТ-ээс хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хураангуй тайланг олон нийтэд толилуулж байна.

MNB ХӨТӨЛБӨРИЙН БОДЛОГО, ШИНЭЧЛЭЛ

МҮОНРТ нь “Олон нийтийн радио, телевизийн тухай хууль”-д заасан хөтөлбөрийн бодлогыг хэрэгжүүлэх, олон улсын нжил төстэй байгууллага, цаг үеийн шаардлагатай хөл нийлэх, технологийн дэвшилийг нэвтрүүлэх, чанартай төсөл хөтөлбөр, нэвтрүүлэг бэлтгэх, хөтөлбөрийн олон талт байдлыг ханган ажиллахыг зорив.

MNB ОЛОН НИЙТИЙН РАДИО



МҮОНРТ Радиогийн Нэгдүгээр суваг 6207 цаг, Монголын дуу хоолой радио 1680 цаг, P3 радио 5840 цагийн программ бэлтгэн дамжуулсан байна. 2019 онд Монголын радиогийн 85 жилийн ой тохиолоо.

Ойн хүрээнд “Олон нийтийн радиогийн хөгжлийн чиг хандлага: Радио өргөн нэвтрүүлгийг тоон системд шилжүүлэх нь” олон улсын форумыг 2019 оны 9 дүгээр сарын 1-нд Шангри-Ла зочид буудалд зохион байгуулав. Тус форумд БНХАУ-ын Төв Радио телевиз, ӨМӨЗО-ны “Талын дуу хоолой” радио, ОХУ-ын Буриад, Халимагийн радио, БНТУ-ын TRT болон Японы соёлын элч нараас бүрдсэн 13 төлөөлөгч уригдан ирлээ. Монгол Улсад суугаа гадаадын дипломат төлөөлөгчийн газрын хэвлэлийн төлөөлөгчид, Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа FM радиогийн удирдлагууд, харилцаа холбооны инженер, техникийн ажилтан, судлаачид оролцсон юм. ОНР-ийн 85 жилийн ой, MNB спорт сувгийн нэг жилийн ойд зориулсан хэвлэл мэдээллийн байгууллагуудын дунд сагсан бөмбөг, волейболын төрлөөр 56 багийн 400 гаруй тамирчдыг хамарсан тэмцээнийг амжилттай зохион байгуулав.

Ажилтнуудынхаа боловсрол, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор байгууллагадаа болон бусад дотоод, гадаадын мэргэжлийн сургуулиудад сургалтад хамрууллаа. 2019 онд байгууллага дээр зохион байгуулсан 669 цагийн сургалтад давхардсан тоогоор 2399 ажилтан хамрагдсан байна. ВГИК буюу С.А.Герасимовын нэрэмжит Москвагийн Бүх Оросын Кино урлагийн их сургуулийн Эрхүүгийн салбар мөн Байкалын Их Сургуульд МҮОНРТ-ийн 200 гаруй сэтгүүлч, уран бүтээлч, инженер техникийн ажилтан богино хугацааны сургалтад хамрагдла. Мөн тус сургуультай “Хамтын ажиллагааны хэлэлцээр” байгуулснаар МҮОНРТ-ийн ажиллагсдыг ОХУ-ын Ерөнхийлөгчийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд дээд болон тусгай мэргэжлийн чиглэлээр өдөр, эчнээ ангиудад сургах боломж нээгдээд байна. Мөн МҮОНРТ-ийн Ерөнхий захирал Л.Нинжамц АНУ-ын IGlobal болон Bay Atlantica их сургуультай хамтран ажиллах санаамж бичигт гарын үсэг зурав. Ингэснээр МҮОНРТ-ийн 10 ажилтан бакалаврын дөрвөн жил, магистрын хоёр жилийн 100 хувийн, 10 ажилтанд 50 хувийн тэтгэлгийг суралцах идэвх, голч оноо зэргийг харгалзан өгөхөөр болсон юм.

Урт, богино хугацааны сургалтыг тогтмолжуулснаар мэргэжил, ур чадварын түвшин тогтоох нөхцөл бүрдэв. 2019 онд Олон нийтийн радиогийн найман найруулагч, 48 сэтгүүлч, Техникийн төвийн 55 инженер нийт 111 ажилтны дунд мэргэжил, ур чадварын түвшин тогтоох шалгалтыг амжилттай зохион байгууллаа.

ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ MNB. Сонсогч, үзэгчдийн санал, хүсэлт, гомдлыг утсаар болон цахим хуудсаар тогтмол хүлээн авдаг бөгөөд 2019 онд нийт 554 санал хүсэлт иржээ. Эдгээрийн 483 нь асуулт, долоо нь гомдол, 63 нь санал хүсэлт байв. Эдгээр санал хүсэлт, гомдол, талархалыг холбогдох уран бүтээлчдэд уламжилж, тухай бүр шийдвэрлэж ажиллав. МҮОНРТ-ийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, студи, тоног төхөөрөмжийг танилцуулах зорилготой “MNB-тэй танилцах аялал”-г 40 удаа зохион байгуулж, нийт 984 сонсогч, үзэгч оролцож, танилцсан байна.

2019 оны эхний улиралд анх удаа МҮОНРТ-ээр “Үзэгчийн аудит”, МҮОНРТ-гоор “Сонсогчийн аудит” нэвтрүүлгийг зохион байгуулж, удирдлагууд болон мэргэжлийн судлаач, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Өвөрхангай аймагт Радиогийн 85 жилийн ойд зориулан “Радио сонсогчдын уулзалт”-ыг зохион байгуулж, Монголын радиогийн хөтөлбөр, үйл ажиллагааг сурталчилж, олон нийтийн санал бодлыг сонсч, тусгайлсан нэвтрүүлэг бэлтгэв.

Олон нийтэд олон нийтийн радио, телевизийн талаар мэдлэг, ойлголт өгөх зорилгоор ОНР-ийн тухай хуулийн заалтуудаар дөрвөн төрлийн видео шторк хийж, бүх сувгаараа өдөрт 12 удаа цацаж байна.

ОЛОН НИЙТ БА НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА. МҮОНРТ, ХСҮТ хамтран найман жилийн өмнөөс “Хавдрын эсрэг үндэсний аян”-г санаачилж, Монгол орон даяар өргөн чар хүрээтэйгээр есөн удаа зохион байгуулж ирлээ. Улмаар МҮОНРТ-ээс санаачилж УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хавдар судлалын үндэсний төв, Худалдаа хөгжлийн банктай хамтран “XXI зуун-Хавдаргүй Монгол 1000 гэр бүлийн зөвлөгөөн”-ийг Төрийн ордны “Их танхим”-д зохион байгууллаа.

Гал, үер усны гамшигаас урьдчилан сэргийлэх, тамхи, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох гэх зэрэг 100 гаруй шторк олон нийтэд түгээжээ.

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА. Олон улсын байгууллага, радио, телевизүүдтэй хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах, уламжлалт харилцаатай гадаад орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, олон улсын байгууллагатай идэвхтэй хамтран ажиллах, шинээр хамтын ажиллагаа өрнүүлэх, олон улсын байгууллагын оролцоо дэмжлэгтэй хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг идэвхжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллалаа.

МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөл болон удирдлагын багийн төлөөлөл 2019 оны 11 дүгээр сарын 16-23-ний өдөр Япон Улсад зохион байгуулагдсан Ази-Номхон далайн өргөн нэвтрүүлгийн холбооны /ABU/ Ерөнхий Ассемблейн 56 дугаар чуулга уулзалтанд оролцов. Чуулга уулзалтын үеэр Ерөнхий Ассемлейн чуулган болон салбар хуралдаануудад оролцож, албан уулзалт хийж, холбогдох асуудлуудаар санал солилцон цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн талаар ярилцаж, тодорхой үр дүнд хүрсэн болно.

МҮОНРТ-ийн Ерөнхий захирал Л.Нинжамц 2019 оны зургаадугаар сард Камбожид болсон Азийн Хэвлэл мэдээллийн дээд хэмжээний уулзалтанд оролцох үеэрээ Азийн Өргөн нэвтрүүлгийн Хөгжлийн Институт-АИВД байгууллагад 2012 оноос хойш үүссэн өрийн асуудлыг хөндөн нухацтай ярилцсан юм. Үүний үр дүнд одоогийн байдлаар, 2014, 2015, 2016, 2019 оны сургалтын хураамжийн төлбөрийн өрийг цуцлуулав.


МҮОНРТ-ийн төлөөлөгч нар 2019 оны 04 дүгээр сарын 21-23-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотноо “Нэг бүс нэг зам” хэвлэл мэдээллийн нийгэмлэгээс зохион байгуулсан “4K+5G” буюу 5G харилцаа холбооны V үеийн дамжуулалтын технологи, 4K дүрсийн технологийн инноваци форумд амжилттай оролцоод оролцов.

Форумд нийт 25 улсын 50 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын 150 төлөөлөгч оролцож, МҮОНРТ-ийн Ерөнхий захирал Л.Нинжамц “Нэг бүс нэг зам” дагуух улс орнуудын хэвлэл мэдээллийн шинэчлэлийн зам” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путны санаачилгаар тав дахь жилдээ зохион байгуулсан Дорнын эдийн засгийн V чуулга уулзалтад МҮОНРТ-ийн Ерөнхий захирал Л.Нинжамц оролцож, “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл дэлхийн эдийн засгийн зөөлөн хүч болох нь” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Радио, телевиз хороотой хамтран ажиллах талаар уулзалт хийв. Энэхүү албан уулзалтын хүрээнд одоо хамтран хэрэгжүүлж буй “Сайн байна уу, Өвөрмонгол” “Сайн байна уу, Монгол орон” нэвтрүүлгийг чанаржуулах, дараа дараагийн дугаарыг амжилттай бэлтгэх, БНХАУ байгуулагдсаны 70 жилийн ойд зориулан Монгол Улсын МҮОНРТ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Одон телевиз хамтран зохион байгуулах урлагын тоглолтын бэлтгэл ажил, хөтөлбөртэй танилцав. Мөн уулзалтаар Дорнын уламжлалт баяр болох Цагаан сарын нэвтрүүлэг хамтран бэлтгэх, хоёр орны бөхчүүд оролцсон Үндэсний бөхийн барилдаан зохион байгуулах санал гаргаж, судалгаа, тооцоогоо бэлтгэн, харилцан санал солилцохоор тохиролцов.

МҮОНРТ-ийн Техникийн Төвийн инженерүүдийн төлөөлөл БНХАУ-ын Бээжин хотноо болсон BIRTV-2019 радио телевиз, киноны тоног төхөөрөмжийн үзэсгэлэнд оролцож олон улсын дэвшилтэт техник технологитой танилцлаа. Уг үзэсгэлэнд 20-иод орны 200 орчим медиа групп, техник технологийн компаниуд 500 гаруй павилонд өөрсдийн тоног төхөөрөмж, техник болон програм хангамжийн танилцуулгыг хийсэн. Үзэсгэлэнгийн үеэр зохион байгуулагдсан Радио Телевизийн хамтын ажиллагааны симпозиумд “МҮОНРТ-ийн техник технологийн өнөөгийн байдал, хэтийн төлөв” сэдвээр ахлах инженер С.Оюунчимэг илтгэл тавьж оролцлоо.




2019 онд Монголын радиогийн дэргэдэх “Улаан бүч” чуулгын 40 жилийн ой тохиов. Ойн хүрээнд Хүндэтгэлийн тоглолт зохион байгуулж, үе үеийн багш, уран бүтээлч, сурагчид оролцон 20 гаруй шилдэг найрал дуу толилуулсан юм. Мөн тус чуулгын урын сангийн 20 дуунаас бүрдсэн “Хөгжмийн эгшигт хайрцаг” цомгийг эмхэтгэн гаргав.

Сүлжээний шинэчлэлийн хүрээнд “Тэнхлэг” хөтөлбөрийг шинэчлэн, редакцын програмуудыг хольсноор бүтэц, хийц хэлбэрийн хувьд өгөөжтэй, сонирхолтой боллоо. “Тэнхлэг” болон том хэмжээний нэвтрүүлгийн заавал мөрдөх ёстой бүтэц гаргав.

“Таван эрдэнэ” нэвтрүүлгийн нэрэмжит “Алтан төлийн эзэн” шагналыг 41 дэх жилдээ ХХААХҮЯ хамтран зохион байгуулав. “Алтан төлийн эзэн”, “Улсын аварга тариаланч”, “Улсын сайн малчин” шагнал гардуулахад орон нутагт ажиллаж 25 удаагийн 275 минутын тусгай нэвтрүүлэг хийж сонсогчдын хүртээл болгов.

Халхын голын ялалтын 80 жилийн ойд зориулж “Халх гол 80” түүхийн 10 цуврал, “Халх голын нисэгчид”, “Халх голын баатрууд” 6 цуврал, “Торгон хилийн зүг” дууны тухай тайлбарт нэвтрүүлэг, “Халхын гол” романы уран уншлага, “Халх голын ялалт” 30 минутын тусгай нэвтрүүлэг зэргийг бэлтгэн дотоод гадаадын сонсогчдод хүргэлээ.

МОНГОЛЫН РАДИОГИЙН FACEBOOK, TWITTER ХАЯГИЙН ДАГАГЧИД



Монголын Радио интернэт орон зайд өөрийн хэрэглэгчтэй болох, шинэ медиаг ашиглан сонсогчийн хүрээгээ тэлэхийг зорьж 2019 онд гар утасны аппликейшн бүтээхэд онцгойлон анхаарч ажиллалаа.

Төрийн шагналт зохиолч С.Эрдэнийн “Тэнгэрийн хөвгүүний эцэслэл”, Нацагдоржийн шагналт зохиолч Б.Баярсайханы “Үүр тэмдгээрх айдас”, СГЗ зохиолч Л. Дашнямын “Мянган охидын цууган” тууж, Оросын зохиолч Валентин Распутины “Франц хэлний хичээл” тууж, СГЗ зохиолч До.Цэнджавын “Тэнгэрт боссон тоос”, СГЗ зохиолч Т.Султаны “Жип унасан толгойгүй хүн”, Төрийн шагналт зохиолч Ч.Ойдовын “Солонго”, нэрт зохиолч Д.Урианхайн “Тугалын зүүд” радио жүжиг, “Баруунш зорчсон үлгэр”, “Улаан асрын зүүд” зэрэг Монголын болон дэлхийн сонгомол зохиолоор Алтан сан хөмрөгийг баяжуулав.

2019 онд “Монголын дуу хоолой” радио 1680 цагийн программ бэлтгэж гадаадын сонсогчдод богино долгионоор хүргэжээ. Мөн vop.mn сайтад өдөр бүр мэдээ, нэвтрүүлэг байршуулж, онцлог нэвтрүүлэг, сурвалжилгаа Voice of Mongolia фэйсбүүк пэйжээр дамжуулан сошиал орчны хэрэглэгчдэд хүргэж байна. “Монголын дуу хоолой” радио 2019 онд дэлхийн 35



орноос 2496 захидал, и-мэйл хүлээн авчээ. Монголын соёл уламжлалыг сурталчлах зорилготой “Монгол дархан” 10 цуврал, “Монгол үндэсний хөгжмийн зэмсэг” 10 цуврал, Халх голын ялалтын 80 жил, Монгол-Хятадын дипломат харилцааны 70 жилд зориулсан цуврал нэвтрүүлэг бэлтгэжээ. Мөн Хятадын сонсогчдын дунд “Миний төссөөн анхны Монгол дуу”, “Монгол орон-Миний төссөөлд” эсээ бичлэгчдийн уралдаан зарлан явуулав.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн нэгдүгээр бүлгийн зургаадугаар зүйлд заасны дагуу 2019 онд МҮОНРТ-ээс хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хураангуй тайланг олон нийтэд толилуулж байна.

MNB ОНТ-ИЙН I СУВАГ



МҮОНТ Телевизийн Нэгдүгээр суваг 6800 цагийн программ бэлтгэн дамжуулсан байна.



Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз, "Номадиа Пикчерс"-ийн хамтын бүтээл "Хамгийн азтай үе" телевизийн олон ангит киног бүтээж үзэгчдийн хүртээл болгов. Залуусын хайр дурлал, амьдралын хэв маягийг гэгээлгээр харуулсан "Хамгийн азтай үе" киноны ерөнхий найруулагчаар Н.Байгал, ерөнхий продюсерээр Л.Нинжамц, продюсерээр Г.Гэрэл болон Б.Наранбат ажилласан бол зохиолыг Х.Өнөрцэцэг, Ж.Намуун, Ц.Эрдэнэбилэг, Ч.Хашчулуун нар бичсэн юм.



Монгол Улсын Ерөнхий сайд У. Хүрэлсүхийн ивээл дор Ази, Номхон далайн бүс нутгийн оюутан залуучуудыг оролцуулсан "ABU Roboson 2019 Mongolia" тэмцээнийг МҮОНРТ амжилттай зохион байгуулав. Тэмцээнд 16 орны 17 баг өрсөлдөж Гран при шагналыг Хонконгийн баг, Монгол Улс нэгдүгээр байранд орсон юм.



Монгол Улсын Батлан Хамгаалах яамтай хамтран "Аравт" төслийг хэрэгжүүллээ. ОХУ-ын Батлан хамгаалахын сайд С.Шойгугийн санаачилгаар "Дэлхийн цэргийн наадам" тав дахь жилдээ дэлхийн 10 оронд нэгэн зэрэг явагдсан бөгөөд наадмын шинэ төрөл "Аравт" морин цэргийн уралдаанаас МҮОНТ-ийн баг долоон цуврал нэвтрүүлэг бэлтгэв.



Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны түүхэн 70 жилийн ойд зориулан МҮОНТ болон ӨМӨЗО-ны Монгол "Одон" телевиз хамтран "Найрамдал-70" хүндэтгэлийн тоглолтыг зохион байгууллаа. Тоглолтонд 200 уран бүтээлч оролцов.



"Ээждээ захидал бичээрэй" нэвтрүүлгийг амжилттай зохион байгууллаа. Сэлэнгэ аймгийн Бугант тосгоны 31 настай 10 хүүхдийн ээж Минж бүсгүйг сурвалжилсан нэвтрүүлэг амжилттай болж олон нийтийн дунд түүнд туслах аян өрнөж тухайн гэр бүлд автомашин бэлэглэсэн үйл явдал болсон юм. 11 дэх жилдээ зохиож буй тус уралдааны түүхэнд хамгийн их буюу 4000 орчим захидал ирсэн онцгой тохиолдол боллоо. Биет бус соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд заан сургах, таниулах үүднээс "Тууль хайлах цаг" төсөл нэвтрүүлгийн хүрээнд "Гэсэр" туулийг 10-15 минутаар 18 бүлэг болгон бүтээлээ.



МҮОНРТ, Оросын шинжлэх ухаан, соёлын төв, "Монголын багачууд" ТББ, "КСОРС Монголия", Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 30 жилийн дараа "Мы поедим в Артек" тэмцээнийг гурван үе шаттай зохион байгуулав.

Халх голын ялалтын 80 жилийн ойд зориулж анх удаа "Болор одод" найрал дууны улсын уралдаанд ЕБС, МСҮТ-н найрал дууны 13 хамтлагийн 500 гаруй хүүхэд хамрагдав. Тус уралдааны ялагч СУИС-ийн дэргэдэх лицей сургуулийн найрал дууны "Бадмаараг"



хамтлагийг Москва хотноо болсон Ялалтын баярын хүндэтгэлийн тоглолтод оролцуулж, Монголын хүүхдийн найрал дууны хөгжилд түүхэн хуудас нэмээд зогсохгүй Монгол-Оросын урлаг соёлын хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулсан юм.



ОХУ-ын Батлан хамгаалах яамны дэргэдэх ОХУ-ын Зэвсэгт хүчний "Звезда" телевизтэй хамтран "Халхын голд байгуулсан гавьяа" дөрвөн анги баримтат кино, дөрвөн цуврал "Нефакт" нэвтрүүлэг бүтээв.

Монгол, Вьетнамын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойг тохиолдуулан МҮОНРТ, Вьетнамын VOV хамтран хоёр орны дипломат харилцааны түүхийг өгүүлэх "Түүхийн жимээр" баримтат кино бүтээв.

МҮОНТ, Туркийн TRT телевизийн хамтын уран бүтээл "Өв соёлын өлгий нутгаар" баримтат киног үзэгчдийн хүртээл болголоо.

Азийн таван улс орон БНСУ-ын EBS телевизэд түшиглэн "Азийн гэр бүл" 50 минутын хоёр цуврал баримтат кино бүтээлээ.

ОНТ-ийн Нэгдүгээр сувгаас хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан бага насны хүүхдэд зориулан Монголын Хүүхэддэйн театртэй хамтран "Бүлтээхэй Дэлдээхэй хоёр" хүүхэддэйн жүжиг, биет болоод биет бус өв тээгчид, ахуйн болоод оюуны соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилготой "Өв соёл", инженерийн зохион бүтээх үйл ажиллагаа, инновац, шинэ бүтээл, оновчтой саналыг дэмжих ач холбогдолтой "Монгол инженер", нийгмийн өмнө тулгамдаад байгаа, олон нийтийн эрх ашгийг хөндсөн сэдвүүдээр зочин, оролцогчдын хамтарсан "Нээлттэй хором", залуучуудын амьдрал, уран бүтээлийн талаар хөрөг-ярилцлагын хэлбэрээр хүргэдэг "Зогсохгүй", орчин үеийн хөгжмийн урлагийн "MNB MUSIC", агуулга, хийц, хэлбэр, баримт, хамрах хүрээ зэргээрээ ижил төстэй ток шоунаас ялгардаг "Гэгээн үдэш" зэрэг 40 нэвтрүүлгийг тогтмол бэлтгэн хүргэж байна.

2019 онд олон ангит нийт 13,068 минутын 11 кино худалдан авснаас 11,944 минутын киног орчуулан, дуу оруулж үзэгчдэдээ хүргэжээ. Бүрэн хэмжээний уран сайхны 426 минутын 4 кино, 684 минутын 13 анги Баримтат кино худалдан авснаас 504 минутын баримтат кино гарчээ. Хүүхэддэйн кино болон хүүхдийн 12 төрлийн 4311 минутын нэвтрүүлэг худалдан авсан байна.

МҮОНТ-ээс 2019 онд Монгол түмний уламжлалт Цагаан сар, Үндэсний их баяр наадам, Халх голын ялалтын ой, шинэ жил, олон улсын эмгэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр гэх зэрэг тэмдэглэлт өдөр, баяр ёслолд зориулж, соёл, урлаг, түүх, өв уламжлалыг сурталчилсан нэвтрүүлэг бэлтгэв.

MNB МОНГОЛЫН МЭДЭЭ СУВАГ




Монголын мэдээ суваг 6073 цагийн хөтөлбөр бэлтгэн дамжууллаа.



Тажна жилийн "Цагийн хүрдийн баатар"-ыг нийт 11 номинациар шалгаруулж, цуврал нэвтрүүлэг бэлтгэн, ажил үйлсээрээ манлайлан, сайн сайхан нийгэм байгуулах үйлсэд хүчин зүтгэж байгаа хүмүүсийг алдаршуулан шагнал гардуулах ёслолыг зохион байгуулав. Өмнөх жилийн "Цагийн хүрдийн баатрууд"-ыг нэг жилийн хугацаанд ямар ажил хийж бүтээсэн, мөн нийгэмд тустай сайн дурын ажилд хэрхэн оролцсоныг сурталчлах зорилгоор "Цагийн хүрдийн баатрууд" ярилцлагын нэвтрүүлгийг бэлтгэж үзүүлэв.

Хүмүүсийн хандлагыг эерэг болгох улмаар, сайн дурын хүмүүнлэгийн ажил хийж буй хүмүүсийг алдаршуулах, хүүхэд залууст зөв амьдрах үлгэр дууриалыг үзүүлэхийн тулд "Энэрэнгүй үйлстнүүдээ алдаршуулыя" аянг МУЗН-тэй хамтран хэрэгжүүлэв.

Монголын мэдээ сувгаас бэлтгэдэг мэдээ, мэдээллийн хөтөлбөрийн агуулга, хэлбэрийг сайжруулах үүднээс Өдрийн мэдээллийн хөтөлбөр бэлтгэн хүргэдэг "Хангарьд" студийн тайз мөн Хоёрдугаар студийн тайзыг шинэчлэв.




ОХУ-ын нийслэл Москва хотноо болсон Ялалтын баярын 74 жилийн ойн ёслолын парадыг тусгай эрхтэйгээр Монгол орон даяар шууд дамжуулан үзүүлснээс гадна Халх голын 80 жилийн ойн өдөр буюу 9 дүгээр сарын 3-нд 11.00-17.15 цаг хүртэл нийтдээ 375 минутын тусгай хөтөлбөрийг Монголын мэдээ суваг дангаараа бэлтгэн үзүүлэв. Анх удаагаа олон цагийн шууд дамжуулалтыг олон цэгийг холбож, мэдээ мэдээлэл уран сайхны төрлөөр бэлтгэн үзэгчдэд хүргэв. Мөн түүнчлэн ОХУ-ын Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалыг Сүхбаатарын талбай, Төрийн ордон дотор хоёр цэг болон бусад хуралдаан хэлэлцээ болсон газруудыг техникийн нарийн төлөвлөж бэлтгэл хангасан дэд бүтцийн хүрээнд айлчлалын үйл явдлыг цаг алдалгүй шууд дамжуулан үзүүлэв.



Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг салбар салбараар нь тодорхойлох "Алсын хараа" цуврал нэвтрүүлгийн 18 дугаарыг бэлтгэн үзэгчдэд хүргэв.

Дэлхийн 17 улсад ажиллаж байгаа Монголын мэдээ сувгийн тусгай сурвалжлагч нарыг онлайн-аар сургалтад хамруулж чадавхжуулав. Мөн орон нутгийн сурвалжлагчдын цугларалтыг зохион байгуулж, хоёр өдрийн сургалт зохион байгууллаа.




Монгол Улсад атар газар эзэмшсэний 60 жилийн ойг тохиолдуулан Газар тариалангийн салбарт амжилттай ажиллаж байгаа эрхмүүдийг алдаршуулах цуврал сурвалжилга бэлтгэн үзүүлэв. Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой тасралтгүй, бүтээмж өндөртэй болгоход юун дээр анхаарах мөн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх улмаар, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалан эрхлэхийн тулд ямар асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа талаар "Тариаланчид" цуврал нэвтрүүлгийг бэлтгэн үзүүлэв. Мөн ХХААХҮЯ-тай хамтарч Атрын баатруудыг алдаршуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгууллаа. Үзэгчдэд эрчим хүчний талаар цогц ойлголт өгөх, зохистой зөв дадал сургах зорилгоор Эрчим хүчний үнэ цэнэ сэдэвт уралдааныг Улаанбаатар хот орон нутаг хилийн чанад гэсэн хамрах хүрээнд зохион байгуулж, "Эрчим хүчний үнэ цэнэ" сурвалжилгыг цувралаар бэлтгэн үзүүлэв.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн нэгдүгээр бүлгийн зургаадугаар зүйлд заасны дагуу 2019 онд МҮОНРТ-ээс хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хураангуй тайланг олон нийтэд толилуулж байна.

MNB MNB СПОРТ СУВАГ



MNB Спорт суваг 6205 цагийн хөтөлбөр бэлтгэн дамжууллаа.

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 07 тоот тогтоолоор MNB Спорт сувгийн хамрах хүрээг “Монгол Улсын нутаг дэвсгэрт” болгон хамрах хүрээг өргөжүүлэв.

МҮОНРТ-ийн MNB спорт суваг нь спортын чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулж байгаа ижил төрлийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаас хөтөлбөрийн бодлогоор ялгарах, спортын уралдаан тэмцээнийг цаг алдалгүй түргэн шуурхай үзүүлэх зорилго тавин ажиллалаа. 2019 онд өөрийн эх оронд болоод хилийн чанадад өрнөж байгаа спортын уралдаан тэмцээнийг цаг алдалгүй түргэн шуурхай үзүүлэх зорилтын хүрээнд нийт 81 төрлийн спортын тэмцээн уралдааныг шууд дамжуулан үзүүллээ.


-2019 онд дотооддоо болсон Улс бүсийн чанартай 12 тэмцээн /Жүдо, Самбо,Жюу-Жицу бөх, Бокс, Сагсанбөмбөг, Волейболын лигийн тэмцээн /

- Монгол Улсад зохиогдсон олон улс, тив, дэлхийн чанартай зургаан тэмцээн / Чөлөөт бөхийн Ази тивийн АШТ, Ширээний теннисний Ази тивийн АШТ, Бадминтоны олимпын эрхийн тэмцээн, Казак курес бөхийн Ази тивийн АШТ,Гимнастикийн Ази тивийн цомын тэмцээн/

- Олон улсад зохиогдсон дөрвөн томоохон тэмцээн /Сахалин-2019 Азийн хүүхдийн өвлийн наадам, Самбо бөхийн ДАШТ, Буудлага спортын Дэлхийн цомын тэмцээн./

- Үндэсний спортын чиглэлээр Сар шинийн баярт зориулсан хүчит бөхийн барилдаан, Үндэсний их баяр наадам, Монголын шигшмэл хурдан морьдын Их хурд – 8 уралдаан, Хотгойдын хурд, "Дорнод Монголын хурд" хурдан морьдын уралдаан зэргийг шууд дамжуулан үзүүллээ.


Японы TBS телевизийн “Sasuke ninja warrior” шоу дэлхийн 20 орон үзэгчдэдээ хүргэсэн бол МҮОНРТ энэ төслийн албан ёсны эрхтэйгээр нэвтрүүлсэн 21 дэх орон боллоо. Уг шоунд 300 гаруй оролцогч бүртгүүлснээс үндсэн 130 оролцогч хурд, хүч, авхаалж самбаагаа сорив. Нийт 300 гаруй уран бүтээлч оролцсон энэхүү шоу 90 минутын хугацаатайгаар 13 дугаар бэлтгэн үзэгчдийн хүртээл болгов.



MNB MNB WORLD СУВАГ

MNB World суваг өдөр бүр 11-23 цагийн хооронд, монгол орны талаарх мэдээ, мэдээлэл, түүх, соёл,уламжлалыг сурталчлан таниулах 19-н нэвтрүүлэг тогтмол бэлтгэн, нийгмийн цахим сүлжээгээр зорилтот контентуудаа түгээж байна.

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 07 тоот тогтоолоор MNB World сувгийн хамрах хүрээг “Монгол Улсын нутаг дэвсгэрт” болгон хамрах хүрээг өргөжүүлэв.



MNB World суваг 4380 цагийн хөтөлбөр бэлтгэн дамжууллаа.

Тус сувгийн орчуулгын баг 2019 онд нийт 40,329 минут буюу 672 цагийн видео контентыг орчуулаад байна. Хадмал орчуулгын баг 16,110 минут буюу 268 цагийн дүрс бичлэгт хадмал орчуулга тавьжээ. MNB World суваг нь 2019 оны Үндэсний их баяр наадмын нээлтийг англи хэлээр дөрвөн цаг шууд дамжуулснаас гадна “Aim Race Wrestle” олон улсын анхдугаар бэсрэг наадам, “Modern Vibe” гала концерт, “Global Mind” тоглолт, “Land of Wrestle”, “Archer Nation”, “City of Nomads” зэрэг 10 тусгай контент, наадмын шууд сурвалжилгууд бэлтгэн үзэгчдэдээ хүргэлээ.

•Цагаан сарын баярт зориулан “Lunar New Year preparations in Mongolia”, “Pure Heart of White moon” нэвтрүүлэг, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан “Her Rights in Mongolia” холбоо нэвтрүүлэг, Монгол цэргийн баярт зориулан “Man”, “Love and Motherland” нэвтрүүлгүүд бэлтгэв.

•Мөн түүнчлэн гадаад орноос ч нэвтрүүлэг бэлтгэв. Тухайлбал, “Colors of India” аяллын

тэмдэглэл, “Манжуурын мисс” сурвалжилга, “Чингисийн тахилга - Мөнх шүтээн”, “Монголын соёлын өдрүүд БНХАУ-д”, Евро-Азийн парламентын дарга нарын уулзалт, Франц-Монголын бизнес,эдийн засгийн харилцааны боломжуудын талаар нэвтрүүлэг бэлтгэн хүргэлээ.

•Монгол орныг олон улсад сурталчлах “Ice Diving at Khuvsgul” аяллын нэвтрүүлэг, “Шонхрын баяр 2019”, “Дээлтэй Монгол 2019”, “Олон улсын морьт харвааны тэмцээн 2019”, “Nomads in the Digital Age” олон улсын хурал, “Улаанбаатарын яриа хэлцэл” дээд хэмжээний уулзалт, “Говь Марафон 2019” зэрэг нэвтрүүлгийг шууд болон бичлэгээр дамжуулжээ. MNB World суваг нь үүсэн байгуулагдаад удаагүй ч, “Бүс ба Зам” BRNA байгууллагын мэдээ солилцох дижитал холбооноос “2019 оны хамгийн идэвх зүтгэлтэй хэвлэл мэдээллийн хэргэсэл”, Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн жендерийн мэдрэмжтэй оны шилдэг нийтлэг нэвтрүүлгийн шагнал хүртээд байна.

MNB ЦАХИМ ТАЛБАР. WWW.MNB.MN


МҮОНРТ-ийн уран бүтээлчдийн бэлтгэсэн мэдээ мэдээлэл, уран бүтээлийг олон нийтэд хүргэх, улс орны болон гадаад мэдээ мэдээлэл зэрэг 100 орчим контентыг өдөр тутамд уншигчдад хүргэж байна.

Вэб сайтуудаас мэдээлэл авдаг нийт уншигчдын дийлэнх олонх нь MNB.mn сайтад гарсан мэдээ мэдээллийг хамгийн эцсийн бөгөөд үнэн бодит хэмээн хүлээн авдгаа илэрхийлдэг.


MNB.mn вэб сайт 2019 онд:



2019 онд 2114420 хэрэглэгчээс давхардсан тоогоор 5474892 /2019.11.16-ны өдрийн байдлаар/ ханджээ. Ажлын нэг өдөрт дунджаар 19500 орчим хандалт авч байна. Сайт одоогийн байдлаар олон улсын ALEXA сайт дахь үзүүлэлтээр 63-т эрэмбэлэгдэж байна. Тайлант хугацаанд MNB.mn цахим хуудас руу дэлхийн 183 улс, 7618 хотоос ханджээ.



ТАЙЛАНТ ХУГАЦААНД: Нийт 28353 контент /2019 онд/
Үүнээс:
 1. Монголын радиогоос: 4510
 2. МҮОНРТ болон Монголын мэдээ суваг: 3950
 3. ММ Гадаад мэдээний албанаас: 1843
 4. Албаны эх сурвалж болон өөрсдийн зүгээс бэлтгэсэн: 18050 контент байна.



МҮОНРТ-ийн зүгээс Фэйсбүүк компанид удаа дараалан хүсэлт явуулсны дүнд 2019 оны аравдугаар сарын 1-нд “Mongolian National Broadcaster” Фэйсбүүк хуудсанд “Rights Manager” буюу өөрсдийн бүтээлийг Фэйсбүүк орчинд зохиогчийн эрхээр хамгаалуулах систем нэмэгдлээ. Одоогоор “Хайрлаарай”, “Зогсоогүй”, “16 мм-ийн кино төсөл”, “Эх өв”, “Эртний сургаалаас суралцахуй”, “Бямба гарагийн саятан”, “Халхын голд байгуулсан гавьяа”, “Мартах учиргүй”, “Монголын нинжа дайчид”, “Эрт нахиалсан сарнай” ОАУСК, “Ургацын далай” зэрэг нэвтрүүлгүүдийг бүртгүүлээд байна. Мөн Монголын радиогийн нэвтрүүлгүүдийн эхлэл хэсгүүдийг бүртгүүллээ.

MNB ТЕХНИКИЙН БОДЛОГО, ШИНЭЧЛЭЛ

МҮОНРТ-ийн ашиглаж буй хальсгүй технологийн MAM системд зохиож ажиллах ажлын урсгалын серверүүд, түүний дагалдах техник хэрэгслүүдийг шинэчилж, Далетийн нийлүүлэгч компани болон Xendata-ийн нийлүүлэгч компанитай техникийн дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Монголын радиогийн фондыг тоон болгож хувиргах ажил үргэлжилж Эргэлтийн фондод 209 цаг 15 минутын 527 файл, Алтан фондод 405 цаг 3 минутын 883 файл болгон хувиргав.

Монголын радиогийн 2010 онд ашиглалтанд орсон PowerEdge R310 серверийн хүчин чадлыг сайжруулж, Вэб серверийн зориулалтаар ашиглах зорилгоор дууны интерфэйсийн холболт болоод үйлдлийн системийн /Windows server 2012/ сайжруулалт хийж туршсан нь амжилттай боллоо.

ОНТ-ийн Өглөө хөтөлбөрийн студи, Хангарьд студийн гэрлийн тоног төхөөрөмж, гэрэлтүүлгийн монтажийг бүрэн шинэчиллээ.



ABU Robocon Ulaanbaatar 2019 олон улсын тэмцээнд зориулж олон улсын төлбөр тооцоо бүхий цахим хуудас ашиглалтад оруулж, оролцогч 20 гаруй орны эрх үүсгэж мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж өгөв.

MNB 2020 ОНЫ ЗОРИЛТОТ АЖЛУУДААС:

МҮОНРТ-ийн Ногоон ном болох “Редакцын дүрэм” болон Эрэн сурвалжлах албан нэгжийн дүрмийг боловсруулж, мөрдөх,

“Гэргий” уран сайхны кино, “Торгон цэргүүд” олон ангит уран сайхны кино, “Давхар цагаан зураас” олон ангит уран сайхны кино, “Тусгаар тогтнолын товчоон” цуврал баримтат уран сайхны киног бүтээн, үзэгчдийн хүртээл болгох,

“MNB Гэр бүл” телевизийн суваг нээх,

Японы нийслэл Токио хотноо зохион байгуулагдах зуны XXXII олимпын наадмыг дамжуулах бэлтгэл ажлыг хангах,

МҮОНТелевизиийн аналог хальсны сан хөмрөгийг тоон хэлбэрт шилжүүлэх төслийг эхлүүлэх,

МҮОНРТ-ийн телевизийн сувгуудын ажлын урсгалын 10Gb хурдтай дотоод сүлжээ зохион байгуулах, хадгалах серверүүдийг шинэчлэх,

МҮОНРТ-ийн Мэдээллийн технологийн сүлжээний удирдлага, Мэдээллийн аюулгүй байдлыг шинэчлэх.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИОТЕЛЕВИЗ

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн нэгдүгээр бүлгийн зургаадугаар зүйлд заасны дагуу 2019 онд MYОНРТ-ээс хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хураангуй тайланг олон нийтэд толилуулж байна.



"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО туйм - 31,
Сүхбаатар дүүрэг,
Т хөрөө Улаанбаатар
14230, Монгол
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Хараат бус аудиторовын дүгнэлт

Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн Үндэсний зөвлөлд:

Дүгнэлт

Бид Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн (цаашид "MYОНРТ" гэх)-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээр санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланг (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, MYОНРТ-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээр санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйцэтгэл нь Бүх материаллаг зүйлсийн агуулга Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн яамнаас батлан гаргасан төрийн бус байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, түүний нэмэлт тайлбар тодруулгыг бэлтгэх заавар журмын, аргачлалын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлага энэ тайлангийнхоос Санхүүгийн тайлагналыг агуулдаг хүлээх аудиторовын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын өс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын өс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын өс зүйн дүрмийн санхүүгийн тайлагналын аудиттай холбоотой өс зүйн зохих шаардлагын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр өс зүйн шаардлагауд нийцүүлэн бусад өс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхоо хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудыг тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаж өгч байна. Үүнд:

MYОНРТ нь дүрмийн 1.2-д "MYОНРТ нь олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь ажилладаг бие даасан, хараат бус, ашигын тологоо бус байгууллага юм" гэж заасны дагуу Хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэсэн статус бүхий хуулийн этгээдээр бүртгүүлэн, санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2017 оны 386 тоот тушаалаар баталсан Төрийн бус байгууллага мөрдөх "НББ-ийн дансны жагсаалт, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар, маяг"-ын дагуу бэлтгэж байна.

Иймд MYОНРТ-ийн статус нь санхүүгийн тайлан бэлтгэх буй үзэл баримтлалтайгаа нийцэхгүй байгааг дараах хүснэгтээс харна уу.

www.granthornton.mn



| Байгууллагын статус | Статусыг тодорхойлж буй хууль, дүрэм | Хуулийн дагуу тайлагнаж санхүүгийн тайлагналын үзэл баримтлал |
|---|---|--|
| Хэвлэл мэдээллийн хэрэгсэл | MYОНРТ-ийн дүрмийн 1.2-д "MYОНРТ нь олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь ажилладаг бие даасан, хараат бус, ашигын тологоо бус байгууллага юм" гэж заасан. | ҮЗ-ийн 2012 оны 13 тоот тогтоолоор баталсан НББ-ийн боллогоор баримт бичигт зааснаар Сангийн сайдын 2017 оны 386 тоот тушаалаар баталсан ТББ-д мөрдөх НББ-ийн дансны жагсаалт, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар, маягтын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэнэ. |
| Нийтийн ашиг сонирхлын аж ахуйн нэгж, байгууллага | Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 3.1-д "Олон нийтийн радио, телевиз нь энэ хуулийн дагуу байгуулагдаж, гагцхүү олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашигын тологоо бус хуулийн этгээд мөн" гэж заасан. Мөн хуулийн 16.1-д "Олон нийтийн радио, телевизийн өмч нь олон нийтийн өмч мөн" гэж заасан. | НББ-ийн тухай хуулийн 4.2-д "Энэ хуулийн 4.1.1-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг хангасан, Сангийн сайдын 2016 оны 41 дүгээр тушаалаар баталсан ААНБ-ийн ангилал шалгуур үзүүлэлтийг тогтоох журмын 2.1, 2.2, 4.1 дэх заалтуудын дагуу "Нийтийн ашиг сонирхлын ААНБ" СТОУС-ыг дагаж мөрдөнө. |
| Төсвийн байгууллага | Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 17.1-д "Олон нийтийн радио, телевизийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ: 17.1.5 улсын төсвийн дэмжлэг" гэж заасан. | Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан "төсвийн байгууллага"-ын шалгуурыг хангаж байгаа бол УСНББОУС-ыг дагаж мөрдөнө. |

MYОНРТ-ийн удирдлага нь өөрийн байгууллагын статус нийцсэн санхүүгийн тайлагналын зохистой үзэл баримтлалыг сонгож, НББ-ийн боллогодоо тусгах шаардлагатай байгаа аудитын гол асуудлаар ойлгож байна. Энэ асуудлаар өгсөн аудитын зөвлөмжийг "Удирдлагад хүргүүлсэн захидал"-ын 2.1-д дурьдсан болно.

Уйрблага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Байгууллагын удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залуулагын улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ байгууллагын үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсоолгүй явуулах байгууллагын чадвартай үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторовын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлээ тусдаа санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторовын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн

www.granthornton.mn



аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлж магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас тусдаа санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохиромжтой аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланг хуяалдан, бичиг баримт хураамчаар үйлдэх, санаатайгаар орхиулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхиулах явдалууд багтсан байж болно.

- Байгууллагын дотоод хяналтын үр ашгатай байдлаар дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн боллогоудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадвартай мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторовн тайлангаа тусдаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхварал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторовн тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал байгууллага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулсан шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйцээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тохирохсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилддаг.

Энэхүү Хараат бус аудиторовн тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Б.Осооргарав болно.



Б.ОСООРГАВ
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
2020 оны 03 сарын 31

www.granthornton.mn

Санхүүгийн байдлын тайлан

Өөрөөр тусгайлан заагаагүй бол төгрөгөөр илэрхийлнэ.

| Үзүүлэлт | Тодруулга | 2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|-----------|-----------------------------------|-----------------------------------|
| ХӨРӨНГӨ | | | |
| Эргэлтийн хөрөнгө | | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 4 | 887,664,264.64 | 1,314,436,951.78 |
| Дансны авлага | 5 | 904,724,044.81 | 777,404,509.68 |
| Бусад авлага | 6 | 186,042,922.77 | 335,330,747.26 |
| Бараа материал | 7 | 975,635,820.21 | 1,506,298,554.69 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 8 | 674,672,539.43 | 657,270,982.55 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | | 3,628,739,591.86 | 4,590,741,745.96 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | | |
| Үндсэн хөрөнгө | 9 | 17,381,221,472.16 | 15,361,613,936.16 |
| Биет бус хөрөнгө | 10 | 2,809,563,932.75 | 3,200,248,038.77 |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | | 20,190,785,404.89 | 18,561,861,974.93 |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | | 23,819,524,996.75 | 23,152,603,720.89 |
| ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ | | | |
| Богино хугацаат өр төлбөр | | | |
| Дансны өглөг | 11 | 1,599,043,356.42 | 977,837,466.91 |
| Урьдчилж орсон орлого | 12 | 478,391,468.30 | 273,766,659.90 |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | | 2,077,434,824.72 | 1,251,604,126.81 |
| Урт хугацаат өр төлбөр | | | |
| Урт хугацаат зээл | 13 | 43,380,017.00 | - |
| Өр төлбөрийн нийт дүн | | 2,120,814,841.72 | 1,251,604,126.81 |
| Цэвэр хөрөнгө | | | |
| Нөөц: а) хязгаарлалтгүй | | 5,516,954,224.57 | 5,516,954,224.57 |
| б) хязгаарлалттай | | 10,996,452,270.43 | 8,635,059,669.69 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | | - | 115,539,960.00 |
| Өмнөх үеийн үр дүн | | 4,163,670,079.89 | 5,160,179,018.03 |
| Тайлант үеийн үр дүн | | 1,021,633,580.14 | 2,473,266,721.79 |
| Цэвэр хөрөнгийн дүн | | 21,699,710,165.03 | 21,900,999,594.08 |
| ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГИЙН ДҮН | | 23,819,524,996.75 | 23,152,603,720.89 |

Ерөнхий захирал /Л.Нинюкамц/
Ерөнхий нягтлан бодогч /Ц.Амарбаясгалан/

Үр дүнгийн тайлан

Өөрөөр тусгайлан заагаагүй бол төгрөгөөр илэрхийлнэ.

| Үзүүлэлт | Тодруулга | 2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|-----------|-----------------------------------|-----------------------------------|
| Үндсэн үйл ажиллагааны орлого | | | |
| Нэвтрүүлгийн үйлчилгээний хөлс | | 6,656,268,420.07 | 6,869,568,329.69 |
| Захиалгат нэвтрүүлгийн орлого | 13 | 4,419,397,486.70 | 4,724,178,572.89 |
| Бэлэг, хандив, тусламжийн орлого | 13 | - | 5,000,000.00 |
| Түрээсийн орлого | 13 | 67,179,575.00 | 47,759,452.00 |
| Улсын төсвийн санхүүжилт | 13 | 7,758,845,646.00 | 9,073,347,000.00 |
| Бусад орлого | 13 | 266,202,534.42 | 236,937,937.77 |
| Үйл ажиллагааны орлогын нийт дүн | | 19,167,893,662.19 | 20,966,791,292.35 |
| Үндсэн үйл ажиллагааны зардал | | | |
| Цалин хөлс, шагнал | 14 | 8,056,205,239.49 | 8,874,204,835.63 |
| Нийгмийн даатгалын шимтгэл | | 994,087,122.73 | 1,150,476,169.69 |
| Үйл ажиллагааны зардал | 15 | 9,017,930,013.01 | 8,374,566,087.21 |
| Үндсэн үйл ажиллагааны зардлын дүн | | 18,068,222,375.23 | 18,399,247,092.53 |
| Үндсэн үйл ажиллагааны үр дүн | | 1,099,671,286.96 | 2,567,544,199.82 |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал) | 16 | (78,037,706.82) | (84,277,478.03) |
| Тайлант үеийн цэвэр дүн | | 1,021,633,580.14 | 2,473,266,721.79 |

MYОНРТ
Санхүүгийн тайлан
2019 оны 12 сарын 31

Мөнгөн гүйлгээний тайлан

Өөрөөр тусгайлан заагаагүй бол төгрөгөөр илэрхийлнэ.

| Үзүүлэлт | 2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|-----------------------------------|-----------------------------------|
| Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | 8,589,693,105.43 | 9,992,926,679.53 |
| (а) Гишүүдийн татвараас орсон мөнгө | 4,575,504,444.81 | 5,119,877,163.92 |
| (б) Төсөл хөтөлбөрөөс орсон мөнгө | 3,334,740,986.69 | 4,151,545,770.14 |
| (в) Бэлэг, хандив, тусламж | - | 2,500,000.00 |
| (г) Түрээсийн орлогод хүлээн авсан мөнгө | 167,682,072.01 | 49,162,717.00 |
| (д) Бусад | 511,765,601.92 | 669,841,028.47 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | 15,121,504,695.89 | 16,845,819,613.07 |
| (а) Ажилчдад төлсөн | 7,065,195,006.36 | 7,969,085,312.61 |
| (б) Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,974,937,194.37 | 2,266,380,486.83 |
| (а) Бараа материал худалдан авахад төлсөн | 923,243,893.05 | 1,341,022,193.96 |
| (г) Ашигласан зардал | 221,378,211.06 | 232,907,199.41 |
| (д) Тууш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 213,052,422.00 | 434,501,556.52 |
| (е) Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө | 3,971,556,491.93 | 3,877,908,828.43 |
| (ж) Хүүний төлбөрт төлсөн | 13,632,807.00 | 7,686,279.00 |
| (з) Татварын байгууллагад төлсөн | 737,826,330.12 | 716,043,676.31 |
| (а) даатгалын төлбөрт төлсөн | 682,240.00 | 284,080.00 |
| Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (6,531,811,490.46) | (6,852,892,933.54) |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1. Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого | 31,840,000.00 | 40,026,000.00 |
| 2. Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө | (1,022,682,486.50) | (1,904,819,847.99) |
| 3. Худалдсан хөрөнгө оруулалтын орлого | - | - |
| 4. Худалдаж авсан хөрөнгө оруулалт | (3,913,262,878.00) | - |
| Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (4,904,105,364.50) | (1,864,793,847.99) |
| Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| Банкнаас авсан зээл | - | - |
| Санхүүгийн түрээсийн өглөгийн төлбөр | (21,612,549.00) | (27,239,831.00) |
| Зээлийн төлөлт | - | - |
| Улсаас өгсөн санхүүжилт | 11,672,108,524.00 | 9,073,347,000.00 |
| Хүү ба урамшууллын орлого | 43,380,017.00 | 89,822,266.10 |
| Валютын ханшны зөрүү | 186,11 | |